

Гадаадын иргэн, харьяатын газрын
2026 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн
01/1125 дугаар албан бичгийн хавсралт



**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗАР**

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, АУДИТЫН ХЭЛТЭС

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН 2026 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2026 он

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН 2026 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2026 оны 06 дугаар сарын 11

Улаанбаатар хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Хяналт-шинжилгээ үнэлгээний зорилго нь тус газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, тухайн онд тавьсан зорилт, хүрэх үр дүнг үнэлэх, үр нөлөөг нэмэгдүүлэхэд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, хэрэгжилтийг сайжруулахад зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, дараагийн шатны төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтэд Засгийн газрын 2025 оны 43, 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, саналыг боловсрууллаа.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ


Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам” болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 8 дугаар хавсралтын дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Хууль зүй, дотоод хэргийн сайд 01 дүгээр сарын 05-ны өдөр баталсан.

Гадаадын иргэн, харьяатын газар нь 2 стратеги зорилго, 4 зорилтын хүрээнд 49 арга хэмжээ төлөвлөснөөс 38 арга хэмжээ буюу 77.5 хувь нь “бүрэн хангалттай”, 3 арга хэмжээ буюу 6.1 хувь нь “хангалттай” бол 70 хүртэл хувийн гүйцэтгэлтэй буюу “хангалтгүй” 8 арга хэмжээ нь 16.3 хувийг тус тус эзэлж байна.(Хүснэгт 1, График 1.)

Хүснэгт 1.

Нийт арга хэмжээний тоо	Арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ (хувиар)			Нийт үнэлгээ (хувиар)
	Бүрэн хангалттай	Хангалттай	Хангалтгүй	
	85 буюу түүнээс дээш хувь	70-85 хүртэл хувь	70 хүртэл хувь	
49	38	3	8	85.1

График 1.



Зорилго тус бүрээр авч үзвэл нэгдүгээр зорилгын хүрээнд 3 зорилт 44 арга хэмжээг төлөвлөсөн нь 85.2 хувь, хоёрдугаар зорилго 1 зорилтын 5 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн нь 84 хувиар үнэлэгдлээ. (Хүснэгт 2)

Хүснэгт 2.

Д/д	Стратеги зорилго	Зорилт	Арга хэмжээний тоо	Зорилтын дундаж үнэлгээ (хувь)	Зорилгын дундаж үнэлгээ (хувь)
1	Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог сайжруулна.	Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт	1	70	85.2
2		Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт	13	82.5	
3		Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт	30	87	
4	Төрийн үйлчилгээнд мэдээллийн технологийн дэвшил, инновац нэвтрүүлэх замаар бүтээмж, үр ашгийг дээшлүүлнэ.	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт	5	84	84

Харин зорилт тус бүрээр үзвэл “Технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулна”, “Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна” зорилтод тусгагдсан ажлууд хамгийн үр дүнтэй буюу 100 хувь, “Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ” зорилтод тусгагдсан ажлууд 84.8 хувь, “Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлэх” зорилтод тусгагдсан ажлууд 88.1 хувиар тус тус үнэлэгдсэн. (Хүснэгт 3)

Хүснэгт 3.

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Гүйцэтгэлийн үнэлгээ			Дундаж хувь
			85 буюу түүнээс дээш хувь	70-85 хүртэл хувь	70 хүртэл хувь	
1	2	3	4	5	6	7
1	Зорилт 1.Технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулна	1	-	1	-	70
2	Зорилт 2.Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна.	13	9	2	2	82.5
3	Зорилт 3. Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ.	30	25	-	5	87
4	Зорилт 4. Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ.	5	4	-	1	84
	Нийт	49	38	3	8	80.9

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Байгууллагын 2026 оны хагас жилийн үйл ажиллагааны үр дүнг “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-д заасан аргачлалаар тооцож үнэлэхэд гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 85.2 хувь “бүрэн хангалттай” дүгнэгдсэн нь өмнөх оны мөн үеийн үнэлгээтэй харьцуулахад 12 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа юм. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 49 арга хэмжээнээс удирдлага зохион байгуулалт хангалтгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах шаардлагатай буюу “хангалтгүй” 70 хүртэл хувьтай үнэлэгдсэн 8 арга хэмжээ байна. Үүнд:

1.1.1. “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” системийг шинэчилж, 2.0 хувилбарыг үйл ажиллагаанд нэвтрүүлэх (хэрэгжилт 70 хувь)

1.2.3. Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газарт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, холбогдох журмын талаар цахим сургалт зохион байгуулах (хэрэгжилт 70 хувь)

1.2.5. Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах тухай гадаадын иргэний хүсэлтийг шийдвэрлэх, үрчлэлтийн дараах хяналт тавих (хэрэгжилт 10 хувь)

1.2.12. Монгол Улсаас албадан гаргаж буй гадаадын иргэний жолоодох эрх, арилжааны банкин дахь дансыг хаалгах талаар холбогдох байгууллагад санал хүргүүлэх (хэрэгжилт 33.3 хувь)

1.3.1. Литва Улсын Дотоод хэргийн яамны харьяа Цагаачлалын албатай хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах (хэрэгжилт 30 хувь)

1.3.3. Монгол Улс дахь гадаадын иргэний бүртгэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр судалгааны ажил хийх (хэрэгжилт 30 хувь)

1.3.4. Гадаад сургалт, олон улсын хурал уулзалтад албан хаагчдыг оролцуулах (хэрэгжилт 38.1 хувь)

1.3.5. Монгол Улсын хууль тогтоомжид санал хүргүүлэх, байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаанд хамаарах эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох (хэрэгжилт 62.5 хувь)

1.3.27. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсөвт байгууллагуудын нэгтгэсэн тайлан балансад холбогдох байгууллагаар санхүүгийн аудит хийлгэж, тодруулга, тайлбар гаргах (хэрэгжилт 50 хувь)

2.1.3. Баримт бичгийн хуурмаглалыг таних мэдээллийн системийг хөгжүүлэх (хэрэгжилт 30 хувь)

Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах хүрээнд “бүрэн хангалттай”, “хангалттай” хэдий ч зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтдээ бүрэн хүрээгүй арга хэмжээ болон “хангалтгүй” үнэлгээтэй арга хэмжээг 2026 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр үр дүнг бууруулахгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулан, арга хэмжээний биелэлтийг бүрэн хангаж ажиллах шаардлагатай.

--ooOoo--